

ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛИЙН МАГИСТР, ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРӨӨР СУРАЛЦАГЧИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Дээд боловсролын тухай хууль, Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 сарын 20-ны А/147 тоот тушаалаар баталсан “Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”, “ОТИС-ийн Докторын зэрэг хамгаалуулах дэд зөвлөлийн ажиллах журам”, “Сургалтын үйл ажиллагааны журам”-ын дагуу магистр, докторын ажлыг хэлэлцэх, магистрант, докторантын судалгааны ажлын явцад зөвлөн туслах, удирдан чиглүүлэх ажлыг ОТИС-д зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2 Магистр, докторын судалгааны ажил нь шинжлэх ухааны тодорхой салбарын мэдлэгт тусгагдсан зорилтыг шийдсэн, улс орны нийгэм, эдийн засагт ач холбогдолтой практик асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шийдсэн, урьд өмнө хийгдсэн мэдэгдэж буй бусад шийдлүүдтэй харьцуулж, шүүмжлэлтэйгээр шинэлэг талыг нээн харуулсан, зохих загвар, шаардлагыг баримталсан, тухайн сэдвээр шинэ мэдлэг мэдээлэл, үндэслэл, онол практикийн дүгнэлт гаргасан эрдэм шинжилгээний ажил байна.

Хоёр. Магистрын судалгааны ажлын хэлэлцүүлэгт тавигдах шаардлага

2.1. Магистрантын судалгааны ажлыг жил бүр харьяалах салбар нэгжийн зөвлөн туслах, удирдан чиглүүлэх зорилгоор зохион байгуулах хэлэлцүүлгийг “Их семинар” гэж нэрлэнэ. “Их семинар”-аас магистрын ажлыг урьдчилсан хамгаалалтад оруулах эсэх тухай зөвлөмж, шийдвэр гаргана.

2.1.1. их семинар

2.1.1.1. их семинарыг тухайн салбарын магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дарга удирдан явуулна. Хэд хэдэн салбарын магистрантын ажлыг хэлэлцэх тохиолдолд бүтцийн сургуулийн захирал хурлыг удирдан явуулна.

2.1.1.2. их семинарт тухайн хамгаалуулах зөвлөлийн гишүүдийн ирц 75-аас багагүй байх ба тухайн салбарын эрдэмтэн докторуудаар өргөтгөн зохион байгуулж болно.

2.1.1.3. их семинар нь нээлттэй зохион байгуулагдана.

2.1.1.4. тухайн салбарын магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дарга их семинарыг удирдан, дэгийг тогтоож, оролцогчдод танилцуулан дагаж мөрдүүлнэ.

2.1.1.5. магистрант тус бүрийн судалгааны ажлыг хэлэлцэх нийт хугацаа 30 минутаас илүүгүй байна

2.1.1.6. их семинарын нарийн бичгийн дарга нь хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга байна. Хэд хэдэн салбарын магистрантын ажлыг хэлэлцэх тохиолдолд бүтцийн сургуулийн захирал хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга нараас нэгийг томилно.

2.2. Нарийн бичгийн даргын үүрэг

2.2.1. хэлэлцүүлэгт орох магистрантын нэр, судалгааны ажлын сэдвийг нэгтгэн гишүүдэд урьдчилан тараана.

2.2.2. хэлэлцүүлэгт орох магистрантуудад зохих зөвлөгөө чиглэл өгч бэлтгүүлнэ.

2.2.3. хамгаалах ажлын сэдвийг харгалзан эрдэмтдийг нэмэлт гишүүдээр өргөтгөн оролцуулах талаар санал гаргана.

2.2.4. хурлын зар, мэдээллийг дарга, гишүүдэд хүргэх, хурлын тов өөрчлөгдвөл урьдчилан мэдэгдэх

2.2.5. хэлэлцүүлэгт оролцогч магистрантуудыг бүртгэх, тайлагнах

2.2.6. хэлэлцүүлгийн албан тэмдэглэлийг их семинар зохион байгуулагдсанаас хойш 3 хоногийн дотор сургалтын нэгдсэн албанд хүлээлгэн өгнө.

2.3. Магистрантын үүрэг

2.3.1. судалгааны ажлын товч танилцуулгыг 10-12 хуудаст багтаасан хураангуй бэлтгэж нарийн бичгийн даргад их семинар болохоос 2-оос доошгүй хоногийн дотор ирүүлэх

- 2.3.2. судалгааны ажлын бүрэн эхийг 1 хувь бэлтгэн хувилж хэлэлцүүлэг оруулж ирэх
- 2.3.3. хэлэлцүүлэгт орохыг дэмжсэн удирдагчийн тодорхойлолт авсан байх
- 2.3.4. их семинарт орохын өмнө сургалтын нэгдсэн албанаас улирлын шалгалтын тооцоогүй, нягтлан бодогчоос төлбөрийн тооцоогүй тухай тодорхойлолт авсан байх
- 2.3.5. судалгааны ажлыг 5-8 минутад багтаан танилцуулах
- 2.3.6. их семинарын үеэр өгсөн санал зөвлөмжийг тусган судалгааны ажлыг сайжруулах

Гурав. Докторантын судалгааны ажлын хэлэлцүүлэгт тавигдах шаардлага

3.1 Докторантын судалгааны ажлыг хэлэлцэн, зөвлөн туслах, удирдан чиглүүлэх зорилгоор зохион байгуулах хэлэлцүүлгийг “Профессорын хэлэлцүүлэг” гэж нэрлэнэ. “Профессорын хэлэлцүүлэг”-ээс докторантын ажлыг урьдчилсан хамгаалалтад оруулах эсэх тухай зөвлөмж, шийдвэр гаргана.

3.2 Профессорын хэлэлцүүлгийг ОТИС-ийн эрдмийн зөвлөлийн дарга удирдан явуулна.

3.2.1 профессорын хэлэлцүүлэг эрдмийн зөвлөлийн гишүүдийн ирц 75-аас багагүй байх ба эрдэмтэн докторуудаар өргөтгөн зохион байгуулж болно.

3.2.2 профессорын хэлэлцүүлэг нь нээлттэй зохион байгуулагдана.

3.2.3 эрдмийн зөвлөлийн дарга хэлэлцүүлгийг удирдан дэгийг тогтоож, оролцогчдод танилцуулан дагаж мөрдүүлнэ.

3.2.4 профессорын хэлэлцүүлгийн нарийн бичгийн дарга нь эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга байна.

3.3 Нарийн бичгийн даргын үүрэг

3.3.1 Хэлэлцүүлэгт орох докторантын нэр, судалгааны ажлын сэдвийг нэгтгэн гишүүдэд тараана.

3.3.2 Хэлэлцүүлэгт орох докторантуудад зохих зөвлөгөө өгч бэлтгүүлнэ.

3.3.3 Хамгаалах ажлын сэдвийг харгалзан эрдэмтдийг нэмэлт гишүүдээр оролцуулах талаар санал гаргана.

3.3.4 Хурлын мэдээллийг дарга, гишүүдэд хүргэх, хурлын тов өөрчлөгдвөл урьдчилан мэдэгдэх

3.3.5 Хэлэлцүүлэгт оролцогч докторантуудыг бүртгэх, тайлагнах

3.3.6 Хэлэлцүүлгийн албан тэмдэглэлийг профессорын хэлэлцүүлэг зохион байгуулагдсанаас хойш 3 хоногийн дотор сургалтын нэгдсэн албанд хүлээлгэн өгсөн байна.

3.4 Докторантын үүрэг

3.4.1 судалгааны ажлын товч танилцуулгыг 8-10 хуудаст багтаасан хураангуй бэлтгэж нарийн бичгийн даргад их семинар болохоос 2-оос доошгүй хоногийн дотор гишүүдийн тоогоор хэвлэн ирүүлэх

3.4.2 судалгааны ажлын бүрэн эхийг 1 хувь бэлтгэн хувилж хэлэлцүүлэгт ирсэн профессоруудад танилцуулах

3.4.3 хэлэлцүүлэгт орохыг дэмжсэн эрдэм шинжилгээний удирдагчийн тодорхойлолт авсан байх

3.4.4 профессорын хэлэлцүүлэгт орохын өмнө Сургалтын нэгдсэн албанаас шалгалтын болон сургалтын төлбөрийн тооцоогүй тухай тодорхойлолт авсан байх

3.4.5 судалгааны ажлыг 15-20 минутад багтаан танилцуулах

3.4.6 профессорын хэлэлцүүлгийн үеэр өгсөн санал зөвлөмжийг тусган судалгааны ажлыг сайжруулах